



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Монгол Улсын Их сургууль, Шинжлэх ухааны сургууль

Хөтөлбөрийн нэр: Гадаад хэл, орон судлал (Хятад)

Индекс: D023102

Шинжээчийн баг:

Ахлагч: Т.Төрбат
Гишүүд: Х.Баатархүү
Ө.Саранцэцэг
Б.Оюунчимэг
Д.Батжаргал

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

БМИҮЗ – Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл

БШУЯ – Боловсрол, Шинжлэх ухааны Яам

МУИС – Монгол улсын их сургууль

ШУС – Шинжлэх ухааны сургууль

ХУС- Хүмүүнлэгийн ухааны салбар

АСТ – Ази судлалын тэнхим

ДОӨБ – Дэлхийн Оюуны Өмчийн байгууллага

ЗХШҮБ – Захиргаа, хяналт шинжилгээ, үнэлгээний алба

ЕБС – Ерөнхий боловсролын сургууль

ИДС – Их, дээд сургууль

ОЗ -Оюутны зөвлөл

ӨҮТ –Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан

ХЧБХ – Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын хэлтэс

ХЕХ – Хөтөлбөрийн ерөнхий хороо

CEFR – Европын Холбооны Гадаад Хэлний Нийтлэг Стандарт

CDIO – Conceive Design Implement Operate

PDCA – Plan, Do, Check, Act /Төлөвлөлт, Хэрэгжүүлэл, Үнэлгээ, Үр дүн/

PLO – Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн

HSK – Hanyu shuiping kaoshi /Хятад хэлний түвшин тогтоох шалгалт/

STEEP – Social Trends, Technology, Economic, Environment

OCW – Open Course Ware /Нээлттэй хичээлийн систем/

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Монгол Улсын их сургуулийн Шинжлэх ухааны сургууль /МУИС/ School of Arts and Sciences, National University of Mongolia /NUM/	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Гадаад хэл, орон судлал /Хятад/ Foreign Languages and Area Studies /China/	
Индекс	D023102	
Шинжээчид	Ахлагч: Т.Төрбат Гишүүд: Х.Баатархүү Ө.Саранцэцэг Б.Оюунчимэг Д.Батжаргал	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Н.Түмэнжаргал	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2021-12-07	-Сургуулийн орчин нөхцөл, лаборатори, анги танхим, номын сантай танилцах, -Сургуулийн бэлтгэсэн илтгэл нотолгоотой танилцах, -Оюутнуудтай хийх уулзалт /цахим/, -Төгсөгчидтэй хийх уулзалт /цахим/, -Сургуулийн бэлтгэсэн илтгэл нотолгоотой танилцах.
	2021-12-08	-Шинжээчийн багийн уулзалт, -Ажил олгогчидтой хийх уулзалт /цахим/, -Багш нартай хийх уулзалт, -Сургуулийн бэлтгэсэн илрэл нотолгоотой танилцах , -Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах -Шинжээчийн баг магадлан итгэмжлэлийн эцсийн шийдвэрийг бус, урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэх

Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-өөс эрхлэн мөрдүүлж буй Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд мөрдөх заавар, журмууд, БШУ-ны Сайдын 2014 оны А/174 тоот тушаал, БСШУ-ны Сайдын 2017 оны А/52 тушаал, 2020 оны А/308 тоот тушаал, БМИҮЗ-ийн Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайлан, Шинжээчийн үнэлгээний тайлан болон холбогдох бусад заавар, эрхийн баримт бичиг, БМИҮЗ-ийн Захирлын 2021 оны 11 сарын 16-ны өдрийн А/133 тушаал.
---------------------------	--

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Монгол Улсын Их Сургууль нь бүрэлдэхүүн 6 сургууль, орон нутаг дахь харьяаллын 2 сургууль, үндэсний статустай 3 хүрээлэн, судалгааны бусад нэгжүүдтэй, бакалавр, магистр, докторын түвшний суралцагч, эрдэмтэн багш, ажилчидтай Монгол улсын эрдэм оюуны ууган гал голомт юм.

МУИС-ийг 2016-2024 онд хөгжүүлэх стратегийн төлөвлөгөөнд “МУИС-ийн алсын хараа нь дэлхийн түвшний их сургууль болоход оршино. Үүний дүнд 2024 онд МУИС нь чөлөөт мэдлэг буюу либерал арт уламжлалд суурилсан, бүс нутгийн хэмжээнд тэргүүлэх байр суурьтай судалгааны их сургууль болж улмаар Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд багтаж орно” хэмээн тодорхойлон, энэхүү зорилгод хүрэх, стратегийн тэргүүлэх чиглэлүүдээ тодорхойлон ажиллаж байна.

Энэхүү алсын харааны хүрээнд МУИС нь шинжлэх ухааны үндсэн салбаруудыг хамарсан чөлөөт мэдлэг буюу "либерал арт" уламжлалд суурилсан хөтөлбөртэй, байгалийн ухаан, эдийн засаг, нийгмийн хөгжлийн суурь асуудлаар сургалт, судалгааны ажлыг тогтвортой эрхэлж, эрдэм мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх эрхэм зорилготой академик буюу эрдмийн байгууллага болно.

Гадаад хэл, орон судлал (Хятад) D023102 хөтөлбөрийг МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль Шинжлэх ухааны сургууль хэрэгжүүлдэг.

МУИС нь хятад хэлний чиглэлээр мэргэжилтэнг 1957 оноос бэлтгэж эхэлсэн. ӨҮТ-нд хамруулсан сүүлийн таван жилд хятад хэл, орон судлалаар нийт дөрвөн төгсөлтөөр 106 төгсөгч байгаагаас 2019-2020 оны хичээлийн жилд 18 төгсөгчтэй байна. ШУС-д 2014 онд хөтөлбөрийн болон бүтцийн өөрчлөлт хийж мэргэжлийн индекс шинэчлэн баталсан дагуу эдүгээ хэрэгжүүлж буй тус “Гадаад хэл, орон судлал (Хятад)” D023102 хөтөлбөрийн багц цагийн харьцаа болон дадлагажих цаг зэрэг нь БШУ-ы Сайдын 2014 оны А/174 тоот тушаал, 2017 оны А/52 тоот тушаалаар тавигдсан шаардлагыг тус тус хангасан байна. Эдүгээ МУИС нь Гадаад хэл, орон судлал /хятад/-аар тайлангийг хугацаанд элсэлтийн бодлого баримтлах үндсэн дээр бакалавр тогтвортой бэлтгэж байна.

Гадаад хэл, орон судлал (Хятад) D023102 хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх явцын талаар БМИҮЗ-д ирүүлсэн ӨҮТ-аас үзвэл хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагад нийцүүлэн, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахыг зорьж ажиллаж байна.

Тус хөтөлбөрийн ӨҮТ-г боловсруулах явцад ижил төстэй чиглэлээр бакалавр бэлтгэдэг Европ, АНУ-ын хоёр их сургуулийн хөтөлбөрийн бүтэц, агуулга, кредит цагийн харьцааг харьцуулан судалсан, холбогдох ажиглалт, зохих дүгнэлт хийсэн байна.

МУИС-ийн ШУС-иас Гадаад хэл, орон судлал /Хятад/ хөтөлбөрийн зорилгыг тодорхойлохдоо:

- “Гадаад хэл, орон судлал (Хятад)” хөтөлбөрийн зорилго нь сургалтын хөтөлбөрийг дэлхийн жишигт ойртуулж, оюутанд өргөн сонголт бий болгох МУИС-ийн тэргүүлэх зорилтод хүрч, өнөөгийн нийгмийн шаардлага, хөдөлмөрийн зах зээлд хөрвөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх сургуулийн эрхэм зорилго, зорилттой уялдаж байгаа болно.

Мөн хөтөлбөрийн зорилтуудад:

-“ ...Судалгааны онол, арга зүйн тодорхой мэдлэг, ур чадвар, хандлага эзэмшсэн,

-Төр болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, гадаад харилцаа, олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллах чадвартай мэргэжилтэн бэлтгэнэ” хэмээн тус тус тодорхойлжээ.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Уг хөтөлбөрт 2016 оноос эхлэн хичээлийн жил бүр тогтоосон элсэлтийн төлөвлөгөөний дагуу 25 элсэгч орж байгаа нь уг хөтөлбөр нийгэмд хэрэгцээтэй, хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй, энэ чиглэлийн үндэсний мэргэжилтэнг амжилттай бүрдүүлэн ажиллаж байна гэж үзэхээр байна. /ӨҮТ-221-р тал/.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Маш чадварлаг, тогтвор суурьшилтай ажиллаж буй туршлагатай багш нараас бүрдсэн баг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг
- Хөтөлбөрийн хүрээний бүх хичээл хоорондын уялдаа холбоо маш сайн байгаа нь суралцагчдад цогц мэдлэг олгоход давуу тал болдог байна

Анхаарах асуудал:

- Орон судлалын онолын чиглэлийн хичээлийн агуулга нэмэх

- Орон судлалын чиглэлээр дадлага хийх мэргэжлийн судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах

Зөвлөмж:

- Орон судлалын чиглэлийн эрдэмтэд мэргэжилтнүүдийг улирал тутамд урьж илтгэл хэлэлцүүлэг хийдэг байх.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөгчид болон ажил олгогчидтой хийсэн уулзалтын үр дүнгээс үзэхэд уг хөтөлбөрт хамрагдсан оюутанууд нь “Гадаад хэл, орон судлал /Хятад/” хөтөлбөрийн төгсөгчийн загварт нийцсэн/ӨҮТ-221-р тал/ Хятад хэлний ур чадвартай, Хятад орон судлалын үндсэн мэдлэгийг сайн эзэмшсэн ажил олгогчдын эрэлт хэрэгцээтэй үндэстний мэргэжилтэн бэлтгэж чадаж байгаа нь нотлогдож байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хятад хэлний өндөр мэдлэгтэй, орон судлалаар мэргэшсэн үндэсний боловсон хүчин хүний нөөц бэлтгэхэд жинтэй хувь нэмэр оруулсан байна.
- Оюутан солилцоог сайн хөгжүүлж ихэнх оюутанууд нь БНХАУ-д урт богино хугацаагаар суралцсаны үр дүнд суралцагчдын хятад хэлний түвшин маш сайн байна.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн судалгааг тогтмолжуулж, давтан сургалтыг хэрэгжүүлэх бололцоон судлах

Зөвлөмж:

- Хятад хэлний хэлмэрчлэхүй хичээлд одоо ашиглаж буй танхимын тоног төхөөрөмжийг ашиглан дадлага хийх цагийг нэмэгдүүлэх

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг баталсан, сайжруулалт хийсэн бүх бичиг баримт бүрэн байсан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Монгол улсын хэмжээнд “Гадаад хэл, орон судлал /Хятад/” хөтөлбөртэй ижил төстэй хөтөлбөр хэрэгжүүлж байгаа их сургууль одоогоор байхгүй.
- 2015 онд хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахдаа АНУ, Европийн тэргүүлэх 4 их сургуулийн ижил төстэй хөтөлбөрүүдийг харьцуулалт хийж улмаар өөрийн орны болон сургуулийнхаа онцлогийг шингээж чаджээ.

Анхаарах асуудал:

- Хятад хэлнээс гадна, орон судлалын чиглэлийн хичээлийн агуулга нэмэгдүүлэхэд анхаарах

Зөвлөмж:

- Хятад судлалын олон жилийн туршлага уламжлалтай, жил бүр олон мэргэжилтэй бэлтгэдэг ОХУ, Япон зэрэг орны их дээд сургуулийн Хятад судлалын хөтөлбөрүүдээс зохих нэмэлт агуулга, сайжруулалт хийж болох эсэх,

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын батлагдсан төлөвлөгөө
- Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц
- Дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, удирдамж, анализ
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график
- Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа зэрэг нь зохих шаардлага хангасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Хөтөлбөрөөр олгох онол, практикийн харьцаан дээр практик буюу дадлагын хичээлүүд давамгайлсан байна.
- Суралцагч улиралд дунджаар 12-18 багц цаг судалж байгаа нь оюутны нэг улиралд судалбал зохих цагийн ачааллын зохистой хэмжээнд байна.

Анхаарах асуудал:

- CHIN300 Анхан шатны хятад хэлний унших бичих дадал I, CHIN301 Анхан шатны хятад хэлний унших бичих дадал II гэсэн 2 хичээл нэг улиралд хамт орж байгааг анхаарч сайжруулах
- Төгсөгчидтэй уулзахад суралцагч төгсөх жилийн сүүлийн улиралд л орон судлал мэргэжлийнхээ онцлог шинжийг өнгөц ойлгоод төгссөн гэж хэлснийг анхааралдаа авах

Зөвлөмж:

- Хятад орон судлал, хэл шинжлэл, орчуулга хөтөлбөрийн хичээлүүдийн давхцал их байгааг анхаарах.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Нэгж хичээлийн хөтөлбөрүүд
- Оюутнуудтай хийсэн уулзалтын мэдээлэл
- Сургалтын арга зүйд хийсэн анализ /ӨҮТ-ийн 76-88-р тал/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчийн бүтээлч болон шүүмжлэлт сэтгэхүйг хөгжүүлэх, мэдлэг хуримтлуулах, үзэл бодлоо үндэслэлтэй илэрхийлэх, онолын мэдлэгээ бодит амьдралд хэрэглэх ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн идэвхтэй 34, идэвхгүй 9 сургалтын аргыг хэрэглэж байна.
- Багш нар өөрийн гэсэн бие даасан сургалтын арга зүйтэй, энэ нь багшийн талаарх оюутны сэтгэл ханамжийн судалгааны үнэлгээгээр харагдаж байна.

Анхаарах асуудал:

- Хятад мэргэжилтэн багшийн заасан хичээл сурагчдаас хамгийн бага үнэлгээ авч буй шалтгаан, хичээлийн агуулга, сурах бичигт анализ хийх

Зөвлөмж:

- Багш бүр нээлттэй хичээл зааж, харилцан бие биенээсээ суралцах боломжыг олгох

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Нэгж хичээлийн хөтөлбөрүүд
- Багш нартай хийсэн уулзалтын тэмдэглэл

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС нь бусад сургуулийн багц цагийг тооцох, суралцагч голч дүнгээ хянах, дүнгээ ахиулах боломж олгох үүднээс үндсэн үнэлгээг хэрэглэхээс гадна нэмэлт тэмдэглэгээг хэрэглэдэг.

- Улирлын явцад хичээлд байнга идэвхтэй оролцсон, тухайн хичээлийн явцын шалгалтын бүх хэлбэрүүдэд амжилттай үнэлэгдсэн, үлгэр жишээч оюутанд уг хичээлийн улирлын шалгалтын үнэлгээг шууд тавихыг үгүйсгэхгүй бөгөөд уг асуудлыг суралцагчийн хамт олонд мэдэгдэн, ил тод шийддэг зэрэг нь сайшаалтай байна.

Анхаарах асуудал:

- Ажил олгогчидтой уулзаж байхад төгсөгчдийн хандлага, багаар ажиллах чадвар, санаачлагатай байдлыг чухалчилж байсныг анхааралдаа авах

Зөвлөмж:

- Оюутны мэдлэг чадварыг голлон үнэлдэг, хандлагыг үнэлэх арга, шалгуур тодорхой бус байгааг анхаарах.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалт, судалгаа явуулах анги танхим
- Хичээл орох ангийн гэрэлтүүлэг, агаарын солилцоо
- Хэлмэрчлэхүйн болоод лингафон танхим
- Багш нарын 2 өрөө, багш бүрийн техник хэрэгсэл
- Хичээл орох танхим бүрийн техник хэрэгсэл
- E контент бэлтгэх өрөө

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- XXI зуунд танхимын сургалтад хэрэглэгдэж болох бүхий л техник хэрэгслээр хангаж байдгийг оюутны сэтгэл ханамжийн судалгаа болон төгсөгч оюутны уулзалтаар баталгаажуулав.
- Багш бүрийг техник хэрэгслээр хангаж, багш нарын нэг өрөө нэмж өгсөн.
- Судалгаа явуулах техник хэрэгсэл, интернэтийн хурд зэрэг нь хангалттай байгааг багш, оюутнуудын уулзалтын үр дүнгээс харагдав.

Анхаарах асуудал:

- Анги танхимын хүрээлцээ сайн байгаа ч, 4 давхрын 447 тоот анги олон сурагч нэг дор суралцахад тохиромжгүй жижиг анги учир олон оюутантай поток хичээлийг өөр ангид оруулахаар тохируулах.
- Сургуулийн барилгын насжилттай холбоотойгоор 1 давхарын хичээл орох танхимууд хүйтэн байгаа асуудлыг жил жилээр шийдэж байгаа боловч дорвитой арга хэмжээ авах.

Зөвлөмж:

- Олон оюутантай потокоор орох хичээлийг том ангид оруулах арга замыг хайх.
- Олон жил яригдаж буй хүйтэн ангийн асуудлыг сургуулийн удирдлагуудад дахин уламжилж шийдвэрлэх арга замыг хайх.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Танхимын номын сан
- Хэлмэрчлэхүй танхим
- Лингафон танхим
- E контент бэлтгэх өрөө

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хэлмэрчлэхүй болон лингафон танхимд хичээллэснээр оюутны сурах идэвх, суралцах чадамжийг нэмэгдүүлж байгааг судалгаагаар батлав.
- Танхимын номын сан хичээл орох ангид байрлаж байгаа нь оюутанд ойр, дурын номоо хэрэгцээтэй үедээ ашиглах боломжийг олгож байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн хичээлийг цахимд шилжүүлэх үйл ажиллагааг тогтмол үргэлжлүүлэх.
- E контент хичээлийг нэмэгдүүлэх шаардлагатай.

Зөвлөмж:

- Интернэт орчин тааруу оюутнуудад хүртээмжтэй мэдлэг олгохын тулд e контент хичээлийг бэлдэх.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн номын сан
- Тэнхимын номын сан
- Мэдээлэл технологийн

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Сургуулийн номын сангийн байр болоод байгууламж, интернэт орчин, цахим номын сан, оюутан, эрдэм шинжилгээний танхим зэрэг нь багш, оюутны судалгаа шинжилгээний хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж байгааг бодитой үнэлгээ хийсэн.
- Мэдээллийн эх үүсгэвэр, судалгаа шинжилгээний номын хүрэлцээ арвин байдаг багш, оюутнууд сэтгэл хангалуун байв.

Анхаарах асуудал:

- Тэнхимийн номын санд хятад хэлний дунд, дээд шатны сурах бичиг цөөн байгааг нэмэгдүүлэх.

Зөвлөмж:

- Хятад хэлний дунд, дээд шатны ном, сурах бичгийн хүрэлцээг нэмэгдүүлэх талаар дорвитой ажил болгох.
- Тэнхимийн номын сангийн номыг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх ажлыг түргэвчлүүлэх.
- Оюутан тэнхимийн номын сангаар үйлчлүүлэхэд илүү хялбар болгох зохион байгуулалт хийх.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хятад хэл, орон судлалаар хөтөлбөрийг 2015 оноос хэрэгжүүлж эхэлсэн, 2015 онд хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөг баталсан.
- Хятад хэл, орон судлалаар 2016 оноос эхлэн хичээлийн жил бүр элсэлт авч 125 оюутан элсүүлсэн /ӨҮТ-221-р тал/,одоо 61 оюутан сурч /ӨҮТ-12-р тал/ байгаа.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тэнхим нь оны эхэнд үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, оны эцэст тайлангаа сургуулийн вэбсайтад байршуулдаг нь тайлангийн ил тод байдлыг хангадаг.

Анхаарах асуудал:

- 2016 оноос хойших нийт элсэгчдийн тоо ба одоо сурч буй оюутны тоон харьцааны ялгаа юунаас шалтгаалсан байгааг тодруулж дүгнэлт хийх.

Зөвлөмж:

- Гадаад хэл, орон судлал /Хятад/ хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөгөөр төлөвшүүлэх нийгмийн хариуцлагыг сонгон судлах B2 /Сургалтын төлөвлөгөөний 5%/ хэрхэн хангаж мэргэжлийн төлөвшил, үнэмшил ямар түвшинд олгож байгаад үнэлэлт, шинжилгээ хийдэг байх.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Ази судлалын тэнхим Азийн 6 улс, орны 11 их дээд сургууль, олон улсын байгууллагатай хамтран ажилладаг.
- БНХАУ-аас жил бүр хятад хэлний мэргэжилтэн багш ирж ажилладаг.
- Тэнхимийн багш нараас нийгэмд үзүүлэх үйлчилгээний хүрээнд 2015-2020 онд нийт 26 ажил зохион байгуулсан, оролцсон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2014-2018 онд тус тэнхимийн төлөөлөл 5 багш БНХАУ-ийн их сургуулиудад зочин судлаачаар, 2 багш зочин багшаар тус тус ажилласан.
- Салбарын оюутнууд Наньжиний Мэдээлэл Технологийн сургуульд 1 жилийн оюутан солилцооны хөтөлбөр, Ухань хотын ШУТИС-д урт болон богино хугацааны сургалт, Шэнь-Ян хотын Багшийн их сургуульд зуны сургалтанд тус тус хамрагдаж ирсэн

Анхаарах асуудал:

- **Оюутан солилцооны хөтөлбөрт орон судлалаар 2018-2020 онд 21 оюутан** дээрхи оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдсан байгааг нэмэгдүүлэхэд анхаарах.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн санхүүжилт нь МУИС-ШУС-ийн санхүүгээр нэгдсэн удирдлагаар зохицуулагддаг. Хятад хэлний салбар жилд дунджаар 380 гаруй сая төгрөгийн зарлагатай ажилладаг.

- Нэг оюутанд ногдох зардал 2019,2020 онд 381-384 мян. төгрөг болсон ба сургалтын төлбөрөөс тус хөтөлбөрт 55-57 хувийг зарцуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Оюутны сургалтын төлбөрөөс гадна хөтөлбөр хоорондын орлого, профессорын суурь зардал эх үүсвэрийн орлого, эдгээр орлогын харьцаа ямар байгаа нь тодорхойгүй,
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт, төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү, түүний зарцуулалтын хэмжээ, харьцаанд дүгнэлт хийдэг байх.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хятад хэл, орон судлалаар сүүлийн 5 хичээлийн жил байнга элсэлт авах болсон.
- Хятад хэл, орон судлалын 33 төгсөгчөөс авсан судалгаагаар төгсөгчдийн мэдлэг чадварын талаар судалгаа хийж түүндээ анализ дүгнэлт хийсэн, төгсөгчдийн 15,2 хувь нь төрийн байгууллагад, 33,3 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллаж байгаа, төгсөөд дийлэнхи нь нэг жилийн дотор ажилд орсон байна.
- ӨҮТ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

• Гадаад хэл, орон судлалын хөтөлбөрийн тэнхимийн үйлчилгээний талаар сэтгэл ханамжийн судалгаанд 40 суралцагч хамрагдсанаас 60 хувь нь хангалттай буюу зарим талаар хангалттай, 37,5 хувь нь дунд зэрэг буюу **зарим** талаар хангалтгүй гэж дүгнэсэн байна. **Зарим тал гэдэгт юу орж байгаад анализ хийх.**

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- ӨҮТ: - МУИС-ийн ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхимийн цахим эх үүсвэр, FB чухал үүрэг гүйцэтгэдэг.

- Хөтөлбөрийн профессор багш нар 2015-2020 оны хооронд гадаад дотоодын эрдэм шинжилгээний хуралд 73 илтгэл хэлэлцүүлж, сэтгүүлд 44 өгүүлэл хэвлүүлсээс гадаадад 7 өгүүлэл нийтлэгджээ. **Үүний дотор орон судлалаар 32 илтгэл хэлэлцүүлсэн байна.**

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн багш нар оюутан, олон нийтэд хандсан 40 гаруй бүтээлтэй, үүнд, ном, сурах бичиг, гарын авлага 12 бичиж, 12 ном сурах бичиг орчуулсан, 20-ийг редакторлосон байна.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутан элсүүлэх журмыг жил бүр шинэчлэн боловсруулж, тус журамд элсэлтийн бодлогыг тусган оруулдаг.
- Элсэгчдийн тоо болон элсэгчдийн дундаж оноонд харьцуулсан судалгаа тогтмол хийдэг.
- Элсэгч болон суралцагчдын бүртгэл судалгааг хийж, мэдээлийн нэгдсэн сан бүрдүүлж ажилладаг.
- Шинээр элсэгчдэд зориулсан гарын авлагыг цахим хэлбэрээр байршуулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тус хөтөлбөрөөр элсэгчдийн ЭЕШ-ын дундаж оноо харьцангуй өндөр байна.
- Элсэгч хавсарга болон хос мэргэжлээр сонгон суралцах боломжтой. Хавсарга мэргэжил эзэмшиж байгаа оюутан 130-аас багагүй багц цагийн хичээл, хос мэргэжил эзэмшиж байгаа оюутан 174-өөс багагүй багц цагийн хичээл судална.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчдад чиглэсэн үйлчилгээний ажлыг сайжруулах, оновчтой болгох тал дээр тодорхой ажлуудыг хийсэн байна.

- Оюутанд чиглэсэн сургалт, мэргэжлийн болон урлаг спортын олон арга хэмжээ тогтмол зохион байгуулдаг.
- Оюутнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг сайн хийдэг. Эрүүл мэндийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлсэн тухайд холбогдох тоон судалгаа хийсэн.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оюутнуудыг тогтмол сайн оролцуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2017 онд 5 оюутан БНХАУ-ын Харбины үйлдвэр технологийн их сургуульд “Хятад, Монгол, Оросын олон улсын оюутны хятад хэл, соёл”-ын зуны сургалтанд хамрагдсан.
- Наньжиний Мэдээлэл Технологийн их сургууль, Ухань хотын ШУТИС, Шэнь-Ян хотын Багшийн их сургууль зэрэг сургуульд богино, дунд, урт хугацааны оюутан солилцооны хөтөлбөр тогтмол хамрагдаж байна.
- Тэнхим, салбарын эрдэм шинжилгээний хуралд оюутнууд тогтмол сайн оролцдог.

Анхаарах асуудал:

- Оюутанд үйлчилгээ үзүүлдэг албадын үйлчилгээний талаар сэтгэл ханамжийн судалгаа хийсэн боловч хэзээ хийсэн, ямар зорилгоор хийсэн зэрэг нь тодорхой бус байна.

Зөвлөмж:

- Оюутанд үйлчилгээ үзүүлдэг албадын үйлчилгээний талаар сэтгэл ханамжийн судалгааг тодорхой болгож, дүн шинжилгээ хийх

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Тус их сургуулийн хэмжээнд 45 клуб үйл ажиллагаа явуулдаг бөгөөд оюутнуудын хамрагдах байдал, оролцоо сайн байна.
- Төгсөгчдийг ажлын байртай болгох, суралцагсдад ажил эрхлэх боломж олгох тал дээр сайн анхаарч, янз бүрийн үйл ажиллагаа, арга хэмжээ зохион байгуулдаг.
- Оюутан солилцооны хөтөлбөрт хамруулах, тэтгэлэг олгох тал дээр сайн ажилладаг.
- Оюутнуудын олон нийтийн оролцоо, урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтийн талаар тайлан мэдээ тогтмол хийдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Улсын болон олон улсын чанартай мэргэжлийн буюу хятад хэлний олимпиад, уралдаан тэмцээнд оюутнууд тогтмол амжилттай сайн оролцдог.

Анхаарах асуудал:

- Оюутны сайн дурын клубуудын үйл ажиллагааг дэмжих санхүүжилтийн талаар тайлан мэдээ байхгүй.

Зөвлөмж:

- Оюутны сайн дурын клубуудын үйл ажиллагааг дэмжих санхүүжилтийн талаар тайлан мэдээ хийдэг байх,

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Шилжилт хөдөлгөөний журмын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлэн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэдэг.
- Шилжилт хөдөлгөөний судалгааг тогтмол хийдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Гадаадын болон дотоодын түгээмэл хэрэглэгддэг үнэлгээний системийг МУИС-ийн үнэлгээний системд хөрвүүлэн тооцдог. Мөн гадаадын их дээд сургуулиудын түгээмэл хэрэглэдэг багц цагийг хөрвүүлэн тооцдог.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөлтийн баримт бичгийг батлагдсан загварын дагуу боловсруулж, төгсөлтийн баримт бичиг олгох дүрэм журмын дагуу олгодог ба холбогдох судалгааг хийсэн байна.
- Төгсөлтийн баримт бичигт оюутны мэргэшил, хөтөлбөрийн үр дүн, хувь хүний гүйцэтгэл, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөр нь 9 үндсэн багштай. 2 багш дэд профессор, 2 багш ахлах багшийн зэрэглэлд ажиллаж байна. Сүүлийн 5 жилийн байдлаар 9 доктор, 8 магистр зэрэгтэй багш ажиллаж ирсэн.
- Багш окуутны харьцаа 1:19 /ӨҮТ-252-р хууд./.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хятад судлалын хөтөлбөрийн 9 багшийн 8 нь буюу 88,8 хувь нь докторын зэрэгтэй.
- Түүний 66,6% нь БНХАУ-ын ТОП-100 -д багтах сургуулиудад хамгаалсан

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хятад судлалын багш нар 2015-2020 онд гадаад, дотоодын мэргэжил дээшлүүлэх сургалт, CDIO азийн бүсийн сургалт, өөрийгөө хөгжүүлэх 6 сургалт зэрэгт давхардсан тоогоор 18 багш хамрагдсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2018-2019 оноос “Дижитал Профессорын Студи” нээж профессор багш нарын хичээлийг он лайн –аар дамжуулах, хадгалах, авч үлдэх боломжтой болсон.

Анхаарах асуудал:

- Хүмүүнлэгийн ухааны судлагдахууны онцлог, бусад хүчин зүйлд анализ хийж Профессорын зэрэглэлд багш ажиллуулах нөхцөл бүрдүүлэхэд анхаарах.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн судалгааны санхүүжилтийн журмын дагуу хөтөлбөрийн 9 багш нийт 11 сая төгрөгийн суурь судалгааны санхүүжилт авсан байна.
- Хөтөлбөрийн багш нар дотоод, гадаадын санхүүжилттэй 26 төсөл, дотоодын санхүүжилттэй 8 гэрээт ажилд оролцжээ.
- Хөтөлбөрийн багш нар гадаадад 7, дотоодын сэтгүүлд 37 өгүүлэл хэвлүүлсэн. Үүнээс хөтөлбөрийн багш нарын эрдэм шинжилгээний өгүүллийн 32 нь хятад хэл, орон судлалаар буюу 39 хувь нь орон судлалын чиглэлээр байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн багш нар дотоод, гадаадын санхүүжилттэй 34 төсөл, гэрээт ажилд оролцжээ. Үүний 14 төсөлөөр 85 сая гаруй төгрөг, 108,4 мянган юанийн санхүүжилт авсан

байна. Мөн Гэрээт ажилд 5 багш ажиллаж 3 сая төгрөг, 49,9 мянган ам.доллар, 40 мянган юанийн санхүүжилт авч хэрэгжүүлсэн онцлогтой.

Анхаарах асуудал:

- Зохиогчийн эрхийн гэрчилгээтэй бүтээл хоёр байна. Эрдэм шинжилгээний ажлын төсвөөс Инноваци, ашигтай загвар, патентад зарцуулдаг хэмжээ, харьцаанд анхаарах.

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- 2016 онд аттестачлал явуулж 3 багш “хангалттай” үнэлгээ авсан.
- Хэл шинжлэлийн хөтөлбөрийн багш нарын мэргэжлийн заавал судлах 17 хичээлээс 13 хичээлд авсан **дундаж үнэлгээ /2,52/ байгаа нь МУИС-ийн дундаж онооноос /2,5/ бага зэрэг их.**

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

2017 оны 10-р сард МУИС-ын захиргааны бүтцэд ХЧБХ бие даан байгуулагдсан нь хөтөлбөрийн нэгдсэн зохион байгуулалт стандартаар батлах, хөтөлбөрийн үнэлгээ хийх, хэрэгжилтэд хяналт тавих, явцын сайжруулалт хийх, хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, холбогдох дүрэн журам боловсруулах зэрэг үйл ажиллагаа нэгдсэн зохион байгуулалтаар явагддаг болсон нь том давуу тал юм.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн тогтмол хийж, орчин үеийн чиг хандлага мөн суралцагчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлж чаддаг.
- Манай улсын хятад хэлний болон Хятад судлалын тэргүүлэх багш нар олон жил тогтвор суурьшилтай ажиллаж өөрийн гэсэн сургалтын арга барил тогтож нийгэмд эрэлт хэрэгцээтэй маш сайн хөтөлбөр болж бүрэн нутагшжээ.

Анхаарах асуудал:

- Ирээдүйн орон судлаач нарыг бэлтгэж буйн хувьд орон судлалын онол, судалгааны арга зүйн талаарх агуулгыг холбогдох хичээлд суулгаж өгөх

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн зарим нэг хичээлийн нэршилийг орчин үеийн болон олон улсын чиг хандлагад нийцүүлэх

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөгч нарын 80% нь хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөн ажлын байранд шууд орж байгаа нь сургалтын чанар сайн, хөтөлбөр нь оновчтой байгаа гэж үзэхүйц байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын үйл ажиллагаанд оролцогч бүх талуудын эрх ашиг болон эрэлт хэрэгцээнд нийцсэн хөтөлбөрийг санал болгодог
- Чанарын дотоод үнэлгээ, баталгаажуулалт болон чанарын хөндлөнгийн үнэлгээ, баталгаажуулалт тогтмол системтэйгээр хийдэг нь мөн давуу тал гэж үзэж байна.

Анхаарах асуудал:

- Ажил олгогчидтой хийх санал асуулга, ажлын байрны эрэлт хэрэгцээний талаарх хэлэлцүүлгийн тогтмолжуулах

Зөвлөмж:

- Цаашид салбараар дагнан төрөлжсөн санарийн мэргэжлийн орчуулагч бэлтгэх тогтолцоог санаачлах

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС нь цаашид Азийн топ-100 их сургуулийн нэг болох зорилт тавьж улмаар төлөвлөгөөний дагуу маш амжилттай ажиллаж энэ хүрээндээ үндэсний хэмжээний магадлан итгэмжлэлд бүх бакалаврын хөтөлбөрүүдээ хамруулах мастер төлөвлөгөөг 2018 онд батлуулан хэрэгжүүлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2019 онд МУИС-ийн захиргааны нэгжүүдийн үйл ажиллагаанд Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 стандартыг хэрэгжүүлсэн. Цаашид сургалтын нэгжүүдэд уг чанрын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх боломжтой.
- Монгол улсын тэргүүлэх судалгааны их сургуулийн хувьд өөрийн гэсэн онцлог давуу тал бүхий сургалтын хөтөлбөртэй, салбартаа тэргүүлэх багшлах боловсон хүчин хүний

нөөцтэй, суралцах орчин нөхцөлөөр бүрэн хангагдсан цаашид олон улсад магадлан итгэмжлүүлэх дараагийн алхамаа эхлэх хэмжээнд хүрсэн байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн шинэчлэлт, сайжруулалттай холбогдох мэдээлэлийг тайланд бүрэн тусгаж байх

Зөвлөмж:

- Гадаадын их дээд сургуулиудын орон судлалын хөтөлбөрүүдээс судалгаа хийн зохих хэмжээндээ сайжруулалт хийвэл цаашид олон улсад магадлан итгэмжүүлэхэд дөхөм болох ач холбогдолтой эсэхийг судлах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн “ Гадаад хэл, орон судлал /Хятад/” D023102 хөтөлбөрийн шалгуур хангасан үзүүлэлтийн товчоо

Шалгуур	Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан/хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/
1 Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	3	-	-	
2 Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	3	-	-	
3 Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	3	-	-	
4 Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5	-	-	
5 Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	5	-	-	

6	Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	4	-	-	
7	Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	3	-	-	
Дүгнэлт		Бүрэн хангасан 26, Хэсэгчлэн хангасан 0, Хангаагүй 0.			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын хэрэгжүүлдэг “Гадаад хэл, орон судлал /Хятад” D023102 хөтөлбөрийг БМИУЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Урлаг, хүмүүнлэгийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	Монгол Улсын их сургуулийн Шинжлэх ухааны сургууль /МУИС/ School of Arts and Sciences, National University of Mongolia /NUM/
Хөтөлбөрийн нэр	Гадаад хэл, орон судлал /Хятад/ Foreign Languages and Area Studies /China/
Хөтөлбөрийн индекс	D023102
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> ➤ Хятад судлалын олон жилийн туршлага уламжлалтай, жил бүр олон мэргэжилтэй бэлтгэдэг ОХУ, Япон зэрэг орны их дээд сургуулийн Хятад судлалын хөтөлбөрүүдээс зохих нэмэлт агуулга, сайжруулалт хийж болох эсэх. ➤ Хятад хэлнээс гадна, орон судлалын чиглэлийн хичээлийн агуулга нэмэгдүүлэхэд анхаарах. ➤ Орон судлалын орчин үеийн чиг хандлага, геополитикийн хичээлийн агуулга нэмж болох эсэхийг судлах.
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> ➤ Хятад орон судлал, хэл шинжлэл, орчуулга хөтөлбөрийн хичээлүүдийн давхцыг арилгах. ➤ Оюутны мэдлэг чадварыг голлон үнэлдэг, хандлагыг үнэлэх арга, шалгуур тодорхой бус байгааг анхаарах.
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> ➤ Олон оюутантай потокоор орох хичээлийг том ангид оруулах, олон жил яригдаж буй хүйтэн ангийн асуудлыг сургуулийн удирдлагуудад дахин уламжилж шийдвэрлэх арга замыг хайх. ➤ Хөтөлбөрийн хичээлийг цахимд шилжүүлэх үйл ажиллагааг тогтмол үргэлжлүүлэх. ➤ Интернэт орчин тааруу оюутнуудад хүртээмжтэй мэдлэг олгохын тулд e контент хичээлийг бэлдэх.

	<ul style="list-style-type: none"> ➤ Хятад хэлний дунд, дээд шатны ном, сурах бичгийн хүрэлцээг нэмэгдүүлэх талаар дорвитой ажил хийх. ➤ Тэнхимийн номын сангийн номыг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх ажлыг түргэвчлүүлэх, оюутан тэнхимийн номын сангаар үйлчлүүлэхэд илүү хялбар болгох зохион байгуулалт хийх.
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> ➤ Гадаад хэл, орон судлал /Хятад/ сургалтын төлөвлөгөөгөөр төгсөгчдөд төлөвшүүлэх нийгмийн хариуцлага, мэргэжлээр өсөх боломжийг сонгон судлах B2 /Сургалтын төлөвлөгөөний 5%/ хэрхэн хангаж мэргэжлийн төлөвшил, үнэмшил ямар түвшинд олгож байгаад үнэлэлт, шинжилгээ хийдэг байх. ➤ Оюутны сургалтын төлбөрөөс гадна хөтөлбөр хоорондын орлого, профессорын суурь зардал эх үүсвэрийн орлого, эдгээр орлогын харьцаа ямар байгаа нь тодорхойгүй, ➤ Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт, төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү, түүний зарцуулалтын хэмжээ, харьцаанд дүгнэлт хийдэг байх.
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> ➤ Оюутанд үйлчилгээ үзүүлдэг албадын үйлчилгээний талаар сэтгэл ханамжийн судалгааг тодорхой болгож, дүн шинжилгээ хийх. ➤ Оюутны сайн дурын клубуудын үйл ажиллагааг дэмжих санхүүжилтийн талаар тайлан мэдээг хийдэг байх.
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> ➤ Хүмүүнлэгийн ухааны судлагдахууны онцлог, бусад хүчин зүйлд анализ хийж Профессорын зэрэглэлд багш ажиллуулах нөхцөл бүрдүүлэхэд анхаарах. ➤ Багш нар бүтээл олонтой боловч зохиогчийн эрхийн гэрчилгээтэй бүтээл цөөн байна. Эрдэм шинжилгээний ажлын төсвөөс Инноваци, ашигтай загвар, патентад зарцуулдаг хэмжээ, харьцаанд анхаарах.
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> ➤ Хэрэгжүүлж буй хөтөлбөрийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх зорилтын хүрээнд хийж эхлэж буй тэнхимийн санаачилга, саналыг МУИС-ын удирдлагын хэмжээнд онцгой анхаарал хандуулж, ХЧБХ болон холбогдох бүрэлдхүүн сургуулийн зүгээс арга зүйн туслалцаа байнга үзүүлж дэмжиж ажиллах. ➤ Хөтөлбөрийн явцын сайжруулалтыг тогтсон хугацаанд хийдэг байх.
ШААРДЛАГА: /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал шаардлага бичнэ/	
	<ul style="list-style-type: none"> ➤

Шинжээчийн багийн ахлагч

Т.Төрбат /Шинжээч, Хэл шинжлэлийн доктор, профессор

Шинжээчийн багийн гишүүн

Х.Баатархүү /Монгол Улсын Хятадын түүх соёл судлалын нийгэмлэгийн тэргүүн/

Шинжээчийн багийн гишүүн

Ө.Саранцэцэг /Улаанбаатарын их сургуулийн хятад хэлний салбарын эрхлэгч, доктор, профессор/

Шинжээчийн багийн гишүүн

Б.Оюунчимэг /Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн ахлах багш, доктор/

Шинжээчийн багийн гишүүн

Д.Батжаргал /ШУА-ийн Олон ул судлалын хүрээлэнгийн ЭША, доктор/

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Ш.Эгшиг	Дэд профессор	21 жил	Доктор (Ph.D)	Хэлмэрчлэхүй
2	В.Батмаа	Дэд профессор	14 жил	Доктор (Ph.D)	НУТО, бүтээвэрзүй, сурвалжийн хятад хэл
3	Д.Ундрах	Дэд профессор	18 жил	Доктор (Ph.D)	Анхан шатны ЯСД, Дэлхийн соёл иргэншил
4	П.Уянга	Дэд профессор	21 жил	Доктор (Ph.D)	Анхан шатны ЯСД, Үгийн сан судлал, Бизнесийн хятал хэл
5	Г.Элдэв-Очир	Дэд профессор	22 жил	Доктор (Ph.D)	НУТО, Хятад хэл соёл судлал, Орчүүлгын онол
6	Л.Солонго	Дэд профессор	17 жил	Доктор (Ph.D)	Анхан шатны УБД-1, 2, Бүтээвэрзүй,
7	Б.Гэрэлт-Ирээдүй	Дэд профессор	25 жил	Доктор (Ph.D)	Хятад хэл соёл судлал, Уран зохиопын влитотгал
8	Б.Нэргүйжаргал	Дэд профессор	17 жил	Доктор (Ph.D)	Анхан шатны УБД-1, 2, Хятад хэл-1
9	Т.Чахар	Ахлах багш	21 жил	Магистр	Анхан шатны УБД-1, 2, Хятад хэл-1, 3

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
1	М.Мөнхтуяа	2	УБ
2	С.Анужин	2	УБ

3	Г.Булган	2	УБ
4	М.Золмаа	2	МУИС-ийн 2-р дотуур байр Архангай аймаг
5	Б.Мядагмаа	2	МУИС-ийн 1-р дотуур байр Өвөрхангай аймаг Арвайхээр
6	У.Солонго	2	УБ Увс аймаг
7	Б.Золжаргал	2	УБ Төв. Баянцагаан
8	О.Соёлом	3	УБ БНСУ
9	Г.Энхцэцэг	3	УБ Говь-Алтай аймаг
10	Б.Дэлгэрбат	3	УБ
11	Б.Болор-Эрдэнэ	3	УБ
12	А.Алтанцэцэг	3	УБ Өвөрхангай Хужирт
13	О.Сарангэрэл	3	УБ Сэлэнгэ Мандал
14	Б.Мичидмаа	3	Амгалан Завхан аймаг
15	Б.Одхүү	4	УБ Дархан-Уул аймаг
16	Н.Хонгорзул	4	УБ Баянхонгор аймаг
17	Б.Алтансүвдмаа	4	Өмнөговь Баяндалай
18	Х.Номин-Эрдэнэ	4	УБ
19	Т.Аззаяа	4	Оюутны өргөө-2 дотуур байр Сүхбаатар Баруун-Урт
20	Х.Уянга	4	УБ

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Б.Анармаа	Күнз ХХК	Гүйцэтгэх захирал
2	Золзаяа	НЗДТГ	Төсөл хяналт зохицуулалтын хөтөлбөрийн мэргэжилтэн
3	Цэнгэнбаяр	Төгс нүүдэл ХХК	Захирал
4	Чойжил	Кафе Рестайм	Менежер
5	Ө.Анузаяа	НЗДТГ-ын ГХХэлтэс	Дарга
6	Ариунцэцэг	“Мон-содон ухаан” Дунд сургууль	Захирал
7	Ариунбаяр	“Смарт” ОУ-ын дунд сургууль	Сургалтын менежер
8	Сарангэрэл	Мобиком ХХК	Менежер
9	Б.Соёлсайхан	Жинь Юань Кайтай ХХК	Ерөнхий менежер
10	Цагаан-Очир	Хос жинчин ХХК	Хүний нөөцийн мэргэжилтэн
11	Ч.Ичинхорлоо Б.Батбаяр	ХАА-г дэмжих сан	Хэлтэсийн дарга Газрын дарга
12	Э.Өлзийбуян	Нутгийн Анар ХХК	Орчуулагч, менежер
13	Азжаргал	Номад Бюүтик зочид буудал	Ерөнхий менежер

IV. Төгсөгчдийн нэрс

№	Төгсөгчийн овог нэр	Төгссөн хөтөлбөр	Төгссөн он	Ажлын газар	Албан тушаал
1	У.Цэнгүүн	Гадаад хэлний орчуулга	2018	“Күнз” боловсролын төв	Хятад хэлний багш
2	Д.Чанцалдулам	Гадаад хэлний орчуулга	2018	СЗДТГ	Мэргэжилтэн
3	Э.Наранцэцэг	Гадаад хэлний орчуулга	2019	НЗДТГ-ын Гадаад харилцааны алба	Мэргэжилтэн
4	О.Энхгэрэл	Гадаад хэлний орчуулга	2019	“Смарт” ОУ-ын дунд сургууль	Хятад хэлний багш
5	А.Дуламсүрэн	Гадаад хэлний орчуулга	2020	МУИС ШУС АСТ	Магистрант
6	Х.Дэлгэрмаа	Гадаад хэлний орчуулга	2020	“Шилмэл карго” ХХК	Захиалгын менежер
7	П.Сарантуяа	Гадаад хэлний орчуулга	2020	НЗДТГ Төсөл хяналт зохицуулалтын хэлтэс	Мэргэжилтэн
8	С.Билэгжаргал	Гадаад хэл, орон судлал	2018	Сургалтын төв	Англи хэлний багш
9	С.Эрдэнэзул	Гадаад хэл, орон судлал	2018	ХЭАА	Орчуулагч, менежер
10	Т.Баярдулам	Гадаад хэл, орон судлал	2019	Мобиком ХХК	Оператор
11	М.Урангоо	Гадаад хэл, орон судлал	2020	ХЭАА	Хувиараа
12	Б.Амаржаргал	Гадаад хэл, орон судлал	2020	“Мон-содон ухаан” Дунд сургууль	Хятад хэлний багш
13	Д.Дарьсүрэн	Гадаад хэл, орон судлал	2020	ХАА-г дэмжих сан	Мэргэжилтэн
14	Б.Номин	Хэл шинжлэл	2019	ХЭАА	Хувиараа
15	Б.Бямбажаргал	Хэл шинжлэл	2019	ХЭАА	Хувиараа

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал /албан бичгийг оруулах/

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/